



МОНГОЛ УЛСЫН  
ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 4/111

Улаанбаатар хот

Г Албан томилолтоор ажиллах журам  
батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай тухай хууль, Далайн захиргааны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.2.10 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1.5, 5.2.16, 5.2.17, 5.2.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Далайн захиргааны ажилтнуудыг гадаад улсад болон дотооддоо орон нутагт албан томилолтоор ажиллах үеийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор "Албан томилолтоор ажиллах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, албан томилолтоор ажиллах удирдамжийн загварыг хоёрдугаар хавсралтаар, албан томилолтоор ажилласан тухай тайлангийн загварыг гуравдугаар хавсралтаар, албан томилолтоор ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэн ажиллахыг Далайн захиргааны нийт албан тушаалтнуудад, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Ю.Өлзийжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Далайн захиргааны даргын 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 37 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



000000221

Далайн захиргааны даргын 2024 оны  
06 дугаар сарын 01-ны өдрийн 11 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

9020050812  
ТУЗ2199 & 5202816

## ДАЛАЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Далайн захиргааны ажилтнуудын албан томилотоор ажиллах үеийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах, томилолтын үр дүнд хяналт тавихад энэхүү журмын зорилго оршино.

### Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэхүү журмыг Далайн захиргааны орон тоо, бүтцийн болон гэрээгээр ажиллаж буй бүх албан хаагчид нь /цаашид “ажилтан” гэх/ дагаж мөрдөнө.

### Гурав. Ажилтныг албан томилотоор ажиллуулах

3.1. Далайн захиргааны ажилтнууд нь албан томилот, сургалт, семинар, хурал, чуулган, уулзалт, бусад албан ажлаар гадаад улсад болон дотоодод орон нутагт албан томилот /цаашид “албан томилот” гэх/-оор ажиллахдаа байгууллагын даргын тушаалаар баталсан удирдамжид заасан үүрэг чиглэлийн дагуу ажил үүрэг гүйцэтгэнэ.

3.2. Албан хаагчид нь албан томилотоор ажиллахдаа удирдамж, тушаалыг ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө байгууллагын даргаар батлуулсан байна.

3.3. Албан томилотоор 2 ба түүнээс дээш ажилтны бүрэлдэхүүнтэй явахаар бол тухайн томилолтын хугацаанд ахлан ажиллах ажилтныг /цаашид “Ахлагч” гэх/ заавал томилно.

3.4. Ахлагч нь томилолтын бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах, журам, зааврыг мөрдүүлэх, аяллын шийдвэр гаргах, зөвлөгөө өгөх, шаардлага тавих үүрэгтэй.

3.5. Байгууллагын зүгээс ажилтныг хувийн автомашинеэр зорчихгүй байхад анхаарах ба явах шаардлага гарвал байгууллагын даргын зөвшөөрлөөр явна.

3.6. Ажилтан 5-аас дээш хоногоор албан томилотоор ажиллах тохиолдолд 3 хоног тутамд байгууллагын ХАБЭА хариуцсан мэргэжилтэнд албан томилолтын талаар тогтмол мэдээлж, эргэх холбоотой ажиллана.

3.7. Албан томилотоор ажиллах удирдамжийн төслийг тухайн ажилтан боловсруулж, холбогдох албан тушаалтнуудаас санал аван Захиргаа, удирдлагын хэлтсээр хянуулан байгууллагын даргад танилцуулж, батлуулна.

3.8. Албан томилотоор ажиллахдаа тухайн улс, орон нутаг руу явах зорилго, хугацаа төлөөлөгчдийн бүрэлдэхүүн, зардлын төсөв, түүний эх үүсвэр, хүрэх үр дүн зэргийг

албан томилолтоор ажиллах удирдамжид тодорхой тусгасан байна.

3.9. Ажилтан нь албан томилолтын тушаал батлуулахаас өмнө албан томилолтын замын маршрутыг байгууллагын Үйлдвэрийн ослыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисст гарган өгч, баталгаажуулах ба баталгаажуулсан замын маршрутыг томилолтын тушаалд хавсаргана.

3.11. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг мөрдлөг болгон усан замын тээврийн хяналтын улсын байцаагчид нь хяналт шалгалтын удирдамжийг Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газрын дарга буюу Ерөнхий байцаагчаар тухайн жилийн хяналт шалгалтын төлөвлөгөөнд уялдуулан жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор батлуулах бөгөөд хяналт шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, иргэдэд хяналт шалгалт хийхээс өмнө ажлын 5 хоногоос багагүй хугацаанд мэдэгдлийг хүргүүлсэн байна.

**Дөрөв. Албан томилолтоор ажиллах үйл ажиллагааны чиглэл, баримтлах зарчмын төслийн талаар**

4.1. Албан томилолтоор ажиллахдаа дараах зарчмыг баримтална.

4.1.1. Уг журмын 2.1 дэх хэсэгт хамаарах албан хаагчид албан томилолтоор ажиллах үедээ хөдөлмөрийн аюулгүй байдал, сахилга хариуцлага болон нийтийн албаны ёс зүйг чанд баримтална.

4.1.2. Албан ёсны уулзалт, хурал, зөвлөгөөн, чуулган дээр хэлэх үг, яриа хэлэлцээр хийхдээ зам, тээврийн салбарын гадаад бодлогын нэгдсэн зарчмыг баримтална.

4.1.3. Салбарын бүтээн байгуулалт, хөгжилд хувь нэмэр оруулах гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусlamжийн талаар гадаад улс, олон улсын байгууллагуудтай албан ёсны уулзалт, хэлэлцээр хийхдээ Далайн захиргааны дарга болон бусад удирдлагууд урьдчилан танилцуулж, санал зөвшилцсэн байна.

4.2. Албан томилолтоор ажиллах үед гадаад улсын болон дотооддоо тухайн орон нутгийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтантай албан ёсоор хийсэн уулзалт, яриа, хэлэлцээрийн тэмдэглэлийг заавал хөтөлж, холбогдох ажилтанд хүлээлгэн өгнө.

4.3. Албан ёсны яриа хэлэлцээрийн үеэр яригдсан асуудлыг "Албан томилолтоор ажилласан тухай тайлан"-д тусгаж, хавсарган Захиргаа, удирдлагын хэлтэст ирүүлнэ.

**Тав. Албан томилолтоор ажилласан талаар тайллагнах**

5.1. Албан хаагчид нь албан томилолтоор ажилласан тухай тайланг тухай албаны ахлах мэргэжилтэн болон Захиргаа, удирдлагын хэлтсээр хянуулан байгууллагын удирдлагад ажлын 5 хоногийн дотор танилцуулсан байна.

5.2. Тайланд албан томилолтоор ажиллах үеийн яриа, хэлэлцээрийн тэмдэглэл, байгууллагын танилцуулга, фото зураг тухайн албан томилолттой холбоотой баримт бичгийг тайланд хавсаргана.

**Зургаа. Үүрэг хариуцлага**

6.1. Ажилтан албан томилолтоор ажиллахаас өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг өөрийн шууд харьяалах удирдах албан тушаалтнаас авах бөгөөд батлагдсан "ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгааны бүртгэлийн дэвтэр"-т зааварчилгааг хэрхэн авсан талаар тэмдэглэл хийж, гарын үсгээр баталгаажуулна.

6.2. Албан томилолтоор ажилласан тухай тайлан, түүний мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтэд Захиргаа, удирдлагын хэлтэс хяналт тавина.

6.3. Албан томилолтоор ажилласан ажилтан томилолтын хугацаа дууссаны дараа ажлын өдрөөс ажлын цагийг баримтлан ажиллах бөгөөд энэ зааврыг зөрчвэл ажил тасалсанд тооцно.

6.4. Албан томилолтоор ажилласан ажилтан буцаж ирснээс хойш тайлангаа хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1 -д заасны дагуу хариуцлага тооцох үндэслэл болно.

### **Долоо. Хориглох зүйл**

7.1. Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 хэсэгт зааснаар "Монгол улсын олон улсын гэрээнд заасан болон Монгол улс, гадаад улсын төрийн байгууллагын хооронд харилцан тохиролцсон албан томилолт болон ажиллаж байгаа төрийн байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхдээ аж ахуйн нэгж, иргэн, түүний дотор гадаадын байгууллага, иргэний зардлаар гадаад, дотоодод зорчих"-ыг хориглоно.

Далайн захиргааны даргын 2024 оны  
06.. дугаар сарын 01..-ны өдрийн 01.. дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

9026050612  
ТУ32198 А 5202018

“АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ УДИРДАМЖ”-ИЙН ЗАГВАР

1.	Хаана ажиллах /улс, хот, орон нутгийн нэр/	
2.	Хугацаа	
3.	Оролцогч /Ахлан явах хүн/	
	Төлөөлөгчдийн бүрэлдэхүүн	
4.	Зардал /Санхүүжүүлэх эх үүсвэрийг бичнэ/	
5.	Зорилго	
6.	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	
7.	Хүрэх үр дүн	
8.	Тайлагнах хугацаа	

Боловсруулсан:

/овог, нэр, албан тушаал/

Далайн захиргааны даргын 2024 оны  
06. дугаар сарын 01-ны өдрийн 04 дугаар  
тушаалын түрэлдүүлжилж хавсралт

0020050012  
ТУЗАЛСАН ТАЙЛАН

“АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАСАН ТУХАЙ ТАЙЛАН”-ГИИН ЗАГВАР

1.	Тайлан бичсэн огноо	
2.	Томилолтын зорилго, шийдвэрийг дурдах	
3.	Хаана ажилласан /улс, хот, орон нутгийн нэр/	
4.	Хугацаа	
5.	Ахлан явсан албан тушаалтны овог нэр, албан тушаал	
	Оролцсон төлөөлөгчдийн нэрс, албан туваал	
6.	Утга /үүрэг чиглэлийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайлангаа бичнэ/	
7.	Хавсралт /Хэрэв хавсаргах материал байгаа бол энд тэмдэглэнэ/	

Тайлан бичсэн: /овог, нэр, албан туваал/

Хянасан: /овог, нэр, албан туваал/

Танилцсан: /овог, нэр, албан туваал/

Далайн захиргааны даргын 2024 оны  
06. дугаар сарын 04-ны өдрийн 04 дугаар  
тушаалын дөрөвдүгээр хавсралт

9820050912  
Бүрдүүлэхэд чиглэсэн хөдөлмөр хамгааллын эрхийг хэрэгжүүлэх баталгааг бий болгохтой  
холбоотой харилцааг зохицуулахад энэхүү зааварчилгааны зорилго оршино.

## АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Далайн захиргааны нийт ажилтан, албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хөдөлмөр хамгааллын эрхийг хэрэгжүүлэх баталгааг бий болгохтой холбоотой харилцааг зохицуулахад энэхүү зааварчилгааны зорилго оршино.

Ажилтан нь томилолтоор ажиллахаас өмнө удирдамжийн дагуу хийж гүйцэтгэх ажил, үүрэгтэй холбоотой аюулгүй ажиллагааны зааварчилгаатай зайлшгүй танилцсан байх бөгөөд өөрийн шууд харьялах удирдах албан тушаалтны удирдлага дор зааварчилгааг авч, батлагдсан “ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгааны буртгэлийн дэвтэр”-т тэмдэглэл хийж, гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Зааварчилгааг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажиллана.

### Албан албан томилолтоор ажиллах, замд гарах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа:

- Албан томилолтоор ажиллахдаа томилолтын хуудас, баталсан удирдамж тушаалын хуулбар, бусад баримт бичиг, зөөврийн компьютер /laptop/, албан паспорт, иргэний болон ажлын үнэмлэх зэргийг биедээ авч явна.
- Зайлшгүй, яаралтай тохиолдолд холбоо барих хүмүүсийн мэдээллийг хэвлэж авч явна.
- Зөвшөөрөлтэй, баталгаатай тээврийн хэрэгсэл /автобус, такси, авто машин, галт тэрэг, нисэх онгоц, усан замын тээврийн хэрэгсэл/-ийг сонгож зорчино.
- Бүрэн бүтэн, эвдрэл гэмтэлгүй, засвар үйлчилгээ хийгдсэн, техникийн үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслээр зорчин явна.
- Зорчих улс орон, орон нутгийн цаг агаарын урьдчилсан мэдээг авсан байх шаардлагатай.
- Авто тээврээр зорчих тохиолдолд замын турш Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг сахин биелүүлэх, мөрдлөг болгон зорчино.
- Авто машинд суудлын даруулга бүсийг зүүж хэвших, салхивч цонхоор толгой, гарах гаргахгүй байх, хог хаягдал хаяхгүй байх;
- Албан томилолтын хугацаанд согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэхийг хатуу хориглоно.
- Эдгээр хориглосон зүйлсийг хэрэглэхгүй байхыг жолоочоос мөн шаардаж, шаардлагатай тохиолдолд байгууллагын удирдлагад нэн даруй мэдэгдэнэ.
- Жолоочийн анхаарлыг татах үйлдэл хийхээс зайлсхийж, жолоо барьж байх үедээ гар утсаар ярих, оролдохгүй байхыг жолоочоос шаардана.
- Явган зорчих, зам хөндлөн гарах тохиолдолд гэрлэн дохио болон зөвшөөрөгдсөн гарц гармаар гарч байх;
- Тухайн улс орон, орон нутгийн түүх соёл, уламжлалыг хүндэтгэх, соёлын биет өв үзмэрийг үзэж сонирхохдоо гараар хүрч, гэмтэхээс болгоомжил;
- Нийтийн тээврийн хэрэгслээр зорчих үедээ бие зөв авч явах, бэлэн мөнгө, үнэт эдлэл, гар утас, бусад /зөөврийн компьютер, албан паспорт, иргэний болон ажлын үнэмлэх, түлхүүр/ эд зүйлээ эзгүй ил задгай орхих, гэмт этгээдийн анхааралд өртөхгүй байхад анхаарах;

- Тээврийн хэрэгсэл saatаж, хээр гадаа хоноглох тохиолдолд эрсдэлийг урьдчилан тооцож хөдөө, орон нутагт явахдаа заавал аяны хөнжил, хэрэгсэл, майхан авч явах;
- Улирал, цаг уурын онцлогт хувцсаа тохируулан өмсөх, нар салхинаас хамгаалах шил, тос хэрэглэх;
- Ариун цэвэр, ахуйн хэрэглээний зүйлс, хэрэгцээт ойр зуурын эм, боолт /лент/ зэргийг авч явах;
- Холбоо барих утсаа байнга цэнэгтэй, нээлттэй байлгаж, нэгжтэй байлгах. Мөн сүлжээ барьдаггүй газарт ямар мэдээллийн хэрэгсэл ашиглахаа төлөвлөсөн байх;
- Зорьсон газар, орон нутаг руу очиход аль болох баталгаат, аюулгүй замыг сонгож байх; /гол, мөрөн, нуурын мөстсөн хэсэг, шавар шалбаагтай хэсгээр зорчихгүй байх/

#### **Зочид буудал, байр орон сууцад байрлах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа**

- Зочид буудалд байрлаж хоноглох үедээ хаалга цонхыг сайтар шалгах, хааж түгжиж байх;
- Зочид буудлын өрөөний хаалга автоматаар түгжигдэхээс болгоомжил,
- Байрласан газар, зочид буудлыг орхин явах тохиолдолд хаяг байршлыг сайтар тогтоож, шаардлагатай тохиолдолд хаяг байршил бүхий танилцуулгыг биедээ авч явах;
- Өрөөндөө танихгүй хүнийг бүү оруул, үл таних хүнийг дагаж явахаас зайлсхийх;
- Гэмт халдлагад өртвөл цагдаа хууль сахиулах байгууллага, эмнэлэг, /102, 103, 105 зэрэг тусгай дугаарт мэдэгдэх/ тухайн улсад суугаа өөрийн орны элчин сайдын яам, консулын газарт даруй мэдэгдэх хэрэгтэй.
- Тухайн газрын гудамж, талбайд олон хүн цугларсан, олон нийтийн бослого үймэн болсон газарт очих, согтуу хүмүүсээс зайлсхийж байх;
- Өрөөнд галт зэвсэг, /үүнд үзмэр хэлбэрээр хадгалагдаж байгаа зэвсэг хамаарна/ тэсэрч дэлбэрэх бодис, дэгдэмхий хий хадгалж байгаа эсэхийг шалгах;
- Ил хүйтэн зэвсэг /хутга, хурц үзүүр бүхий зүйл/ хадгалж байгаа эсэхийг шалгах;
- Зэрлэг ан амьтанд хазуулах, мал, амьтны гоц халдварт өвчлөлд өртөх нөхцөлөөс болгоомжил,
- Хорио цээр тогтоосон гоц халдварт өвчний бүс, нутагт зорчихгүй байж, халдвараас сэргийлж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж байх;
- Ахлагч нь томилолтын бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах, журам, зааврыг мөрдүүлэх, аяллын шийдвэр гаргах, зөвлөгөө өгөх, шаардлага тавих үүрэгтэй.
- Холбоо барих хэрэгсэл ашиглах боломжгүй газарт saatсан, осолдсон, гэмтсэн тохиолдолд ахлагч нь хамгийн ойр орших айл, хот суурин луу тусламж дуудах хүнийг томилж явуулна.
- Ахлагч нөхцөл байдлыг үнэлж, шаардлагатай анхан шатны арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хэрэгжүүлнэ;
- Нөхцөл байдлаас шалтгаалж ажлын төлөвлөгөө, маршрут өөрчлөгдөх тухай бүрд ахлагч нь байгууллагын ХАБЭА хариуцсан ажилтанд мэдэгдэх;
- Ажилтан 5-аас дээш хоног албан томилолтоор ажиллах тохиолдолд З хоног тутамд байгууллагын ХАБЭА хариуцсан ажилтанд албан томилолтын талаар тогтмол мэдээлж, байх;
- Осол тохиолдсон үед ажилтан нь өөрийн шууд удирдлага болон байгууллагын ХАБЭА хариуцсан ажилтанд мэдэгдэж, шуурхай авах арга хэмжээний талаар зааварчилгаа авна;

#### **Жолоочид өгөх зааварчилгаа**

- Өдрийн цагаар буюу нартай байгаа үед замд явах;

- Замд гарахын өмнө орон нутгийн цаг агаарын урьдчилан мэдээг авсан байх;
- Албан томилолтоор зорчихдоо батлагдсан зам маршрутыг баримтлан зорчино.
- Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлэх,
- Авто машины хурдыг тохируулахдаа тухайн авто замын зөвшөөрөгдсөн хурдны дээд хязгаараас хэтрүүлэлгүй зорчих;
- Авто зам дээр ажил, үүрэг гүйцэтгэж байгаа хүн, явж байгаа мал, амьтны дэргэдүүр өнгөрөхдөө хурдаа хасаж, түүнд аюул, осолтой байдал үүсгэхгүйгээр зорчих;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар эрх бүхий этгээдээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх,
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцохгүй байх,
- Эвдрэл, гэмтэл, техникийн зөрчилгүй байхаар тээврийн хэрэгслийнхээ бүрэн бүтэн байдлыг хангах;
- Автомашин хаалгыг түгжилгүй онгорхой орхихоос зайлсхийж, хаалгыг тогтмол хааж, түгжиж байх;
- Автозам дээр болон түүний ойр орчимд түр зогсож, ажил, үйлчилгээ гүйцэтгэх үедээ тээвэрлэн яваа зорчигчдод аюул учруулахгүй байх зааварчилгаа өгөх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;
- Тээврийн хэрэгслийн тоормосны систем, жолооны механизм ажиллахгүй болсон, чиргуулийн холбоос (чиргуултэй үед) эвдэрсэн, харанхуй үед болон үзэгдэх орчин хязгаарлагдсан нөхцөлд хол, ойрын буюу ар талын оврын гэрэл асахгүй болсон, цас, бороо орж байгаа үед жолооч талын шил арчигч ажиллахгүй бол хөдөлгөөнөө үргэлжлүүлэхийг хориглоно.
- Хөдөлгөөнд оролцож явах үед тээврийн хэрэгсэлд дээр дурдсанаас бусад гэмтэл тохиолдвол түүнийг засах, хэрэв бололцоогүй бол аюулгүй байдлыг хангаж аль ойр байгаа зогсоол (гараж) буюу засварын газарт очих хүртэл хөдөлгөөнөө үргэлжлүүлэхийг зөвшөөрнө.
- Аян замд явахад автомашинтайгаа цас, шаварт суух, шөнө орой төөрөхөөс болгоомжил.
- Автомашинд байх шаардлагатай зүйлсийг бэлэн байлгах /татлага трасс, домкрат, пужин, нөөц дугуй, дугуйн нөхөөс, багаж хэрэгсэл/;
- Газрын зураг болон Offline navigator /GPS-тэй явах;
- Замыг урьдчилан тооцож аюулгүй замаар явах /төв зам болон автомашины хөдөлгөөн ихтэй замаар зорчих/;
- Гол ус, цасны гүнийг үзэхгүйгээр гатлах гэж оролдохгүй байх;
- Цасан болон шороон шуургатай, цаг агаарын хүнд нөхцөлд замд гарахыг хориглох бөгөөд замд байгалийн гэнэтийн үзэгдэл тохиолдсон үед төөрөхөөс сэргийлж замд хамгийн ойр байрлах айл, хот суурин газрыг олж байрлах, газар орон нутгийн талаар мэдээлэл авах;
- Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд ноцтой хохирол учирсан байж болзошгүй зам тээврийн ослын тохиолдол харсан даруйд очиж бололцоотой тусламж үзүүлэх, цагдаа, эмнэлгийн байгууллагад яаралтай мэдэгдэх, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, эмнэлэгт яаралтай хүргэх,

**Албан томилолтоор ажиллах үед танихгүй газар орон нутагт болон барилга байгууламж, үйлдвэрийн орчинд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа:**

- Тухайн ажлыг, үүргийг аюулгүй гүйцэтгэхэд тохирсон хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгслийг бүрэн өмсөх, зориулалтын дагуу зөв хэрэглэх, бусад бүрэлдэхүүнийг өмсөх, хэрэглэхийг шаардах;
- Тухайн байгууллагын талаарх мэдээллийг сайтар судалж мэдсэн байх;

- Аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцсан байх;
- Тухайн байгууллагын ажилтны удирдлага дор барилга байгууламж, үйлдвэрийн орчинд ажиллах;
- Осол дөхсөн ажлын байр болохыг мэдсэн даруйд тухайн хариуцсан ажилтанд даруй мэдэгдэх, аюулд ойртохгүй байх;

**Ослын үед үзүүлэх анхны тусlamж, авах арга хэмжээ:**

- Шууд удирдлага болон байгууллагын ХАБЭА хариуцсан ажилтанд мэдэгдэх;
- Ямар ч үед сандарч тэвдэлгүй аль болох тайван байх, томилолтын баг бүрэлдэхүүнийг бүртгэх, эрүүл мэндийн байдлыг лавлах;
- Автомшинаас бензин, шатамхай шингэн асгарч буй эсэхийг шалгах, гишүүдийг аюулгүй зайд холдуулах, тэсэрч дэлбэрэхээс урьдчилан сэргийлэх;
- Осолд өртсөн хүнийг тайван байлгах, амьсгалын замыг чөлөөлж, шаардлагатай үед хиймэл амьсгал хийж, чөлөөтэй амьсгалах нөхцөлөөр хангах, эмнэлгийн тусlamж иртэл хөдөлгөөнгүй байлгах;
- Цус алдаж буй тохиолдолд гол судасны дээд талд боолт хийх, шархыг спиртээр ариутгаж боолт тавих;

--00o--